



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 13 өдөр

Дугаар Анх

Есөнбулаг

Улсын төсөвт үйлдвэрийн газруудын  
онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн  
гэрээний биелэлтийн тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан "Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар болон төсөвт үйлдвэрийн газрын захиралтай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн өмчит "Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар" улсын төсөвт үйлдвэрийн газрын 2022, 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, захирал Д.Батбилэгтэй байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг "Сайн", "Нийтлэг үйлчилгээ" улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал И.Гантулгатай байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг "Хангалттай", "Инноваци бизнес хөгжлийн төв" улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал Т.Эрхэмбаяр байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг "Сайн" гэж тус тус дүгнэсүгэй.

2.2023 оны ажлаараа сайн дүгнэгдсэн "Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар" улсын төсөвт үйлдвэрийн газар, "Инноваци бизнес хөгжлийн төв" улсын төсөвт үйлдвэрийн газруудын захирал, нягтлан бодогч нарт 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний урамшууллыг үйлдвэрийн газрын батлагдсан цалингийн сангаас олгохыг зөвшөөрсүгэй.

3.Улсын төсөвт үйлдвэрийн газрын захирлуудтай байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг 2024 оны 06 дугаар сарын 12-ны өдрөөр дуусгавар болгохыг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг)-т үүрэг болгосугай.

4.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

